



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО

# МОНГОЛ УЛС: ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН ТҮВШИН

(Сүүлийн үеийн тоо баримтаар)



66,38

ДУНДАЖ НАСЛАЛТ

75,96

57 872

ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД  
СУРАЛЦАГЧИД

90 574

60,8%

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН

48,7%

1373

ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН  
ДЭХ ОРОЛЦОО

462



2020 он



# ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН ТҮВШИН

*МОНГОЛ УЛС ЖЕНДЭРИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ОЛОН УЛСАД  
ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН,  
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ  
ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САНХҮҮЖИЛТ  
ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА  
ЖЕНДЭРИЙН СТАТИСТИК*



@ 2020 он


Энэхүү мэдээллийг Жендэрийн үндэсний хорооноос  
жил бүр шинэчлэн гаргана.

# ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ МОНГОЛ УЛСАД

(2020 оны байдлаар)

Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэж байна.

## 1. МОНГОЛ УЛС ЖЕНДЭРИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ОЛОН УЛСАД:



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс нөхөн үржихүйн эрүүл мэнд, улс төрийн төлөөлөл, ажиллах хүчний оролцооны үзүүлэлтэд суурилан гаргадаг Жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлтээр 2018 оны байдлаар Монгол Улс 189 орноос 71-р байранд, Хүний хөгжлийн үзүүлэлтэд суурилан гаргадаг Жендэрийн Хөгжлийн Индексээр 92-р байранд орсон байна.

2020 оны байдлаар Дэлхийн Эдийн Засгийн Форумаас гаргадаг жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлтээр (Global Gender Gap Index Report) дэлхийн улс орнууд жендэрийн тэгш байдлыг хангахад дунджаар 68.6%-тай байна. Монгол Улс нь 70,6% үзүүлэлтээрээ нийт 153 орны дунд 79-р байранд орж байна. Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангаж, Тогтвортой хөгжлийн зорилт 2030 -ын хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхэд эмэгтэйчүүдийн улс төр дэх төлөөлөл болон ажиллах хүчний оролцооны түвшин хангалтгүй байгаа нь гол саад болж байгааг дээрх үзүүлэлтүүд харуулж байна. Мөн эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 9,7 жилээр богино

болоод байгаа нь ноцтой асуудал юм. Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэл буурахгүй байна. Манай улсын хувьд анх удаа 2017 онд явуулсан судалгаагаар хамтрагчтай эмэгтэйчүүдийн 29,7% нь амьдралдаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн бол 17,3% нь бусдын зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн байна. Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэй 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртжээ. (ҮСХороо, ЦЕГ-ын Статистикийн тойм “Гэр бүлийн хүчирхийлэл”-2020)

<b>Жендэрийн зөрүүтэй байдлын индекс</b>	<b>79</b>	<b>0.706</b>
<b>Эдийн засгийн оролцоо ба боломж</b>	<b>29</b>	<b>0.751</b>
Ажиллах хүчний оролцооны түвшин	81	0.812
Ижил ажилд олгож буй цалин хөлс	26	0.730
Багцаалсан орлого	52	0.665
Хууль тогтоогч, удирдах ажилтнууд	29	0.640
Мэргэжлийн ба техникийн ажилтнууд	1	1.000
<b>Боловсрол эзэмшилт</b>	<b>71</b>	<b>0.993</b>
Бичиг үсэгт тайлагдалт	1	1000
Бага боловсролд хамрагдалт	119	0.984
Дунд боловсролд хамрагдалт	1	1000
Дээд боловсролд хамрагдалт	1	1000
<b>Эрүүл мэнд ба амьд гарах боломж</b>	<b>1</b>	<b>0.980</b>
Төрөх үеийн хүйсийн харьцаа	1	0.944
Эрүүл наслалт	1	1.060
<b>Улс төрийн эрх мэдэл</b>	<b>120</b>	<b>0.102</b>
Парламент дахь эмэгтэйчүүд	106	0.206
Сайдын албан тушаал дахь эмэгтэйчүүд	107	0.153
Эмэгтэй төрийн тэргүүнтэй байсан жил	69	0.000

## 2. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН, УДИРДЛАГАЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### А. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН

- БНМАУ-ын 1924 оны анхны Үндсэн хуульд эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш шударга хандах талаар тусгасан нь 1992 оны Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөний гүнзгийрүүлсэн агуулгаар уламжлагдсан бөгөөд уг үзэл баримтлалын дагуу Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталсан.
- Монгол Улсын Засгийн газраас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг (2013-2016), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг (2002-2015), (2017-2021) онуудад баталж үе шаттай хэрэгжүүлж байна. Бодлогод суурилсан төлөвлөгөөт үйл ажиллагааны хүрээнд 1996 оны Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай үндэсний хөтөлбөрөөс эхлэн тооцвол жендэрийн тэгш байдлын чиглэлээр нийтдээ 5 хөтөлбөр хэрэгжүүлжээ.
- 2013 оноос эхлэн салбар, орон нутгийн жендэрийн тусгайлсан бодлого, төлөвлөлтийг хөгжүүлж, өнөөдөр 9 салбарт жендэрийн стратеги, бодлого, 21 аймаг, нийслэл, нийслэлийн 8 дүүрэгт оролцоонд суурилан боловсруулсан жендэрийн дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

Монгол Улс жендэрийн тэгш байдалд чухал ач холбогдолтой олон улсын дараах конвенцид нэгдэн орсон. Үүнд:

Нэгдэн орсон он	КОНВЕНЦИЙН НЭР
1965	<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц (1952) /1952 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1954 оны 7 сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> </ul>
1969	<ul style="list-style-type: none"> <li>Тэгш шан хөлс олгох тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц (1951) /1951 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1953 оны 5 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> <li>Эхчүүдийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц (1952) /1952 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталж, 1955 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> <li>Алагчилахгүй байх /ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/ тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц (1958) /1958 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1960 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> </ul>
1974	<ul style="list-style-type: none"> <li>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966) /Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> <li>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966) /Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> </ul>
1981	Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979) /Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон/

## Б. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


Жендэрийн харилцаа нь нийгмийн амьдралын бүх салбар, чиглэлийг хамардаг тул жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо нь салбар болон нийгмийн оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах чадамжтай байхыг дэлхий нийтээр даган мөрддөг Бээжингийн мөрийн хөтөлбөрт чухалчлан заасан байдаг. Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлсэн, Жендэрийн үндэсний хороо нь ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн 8 яамны Төрийн нарийн бичгийн дарга, төрийн бусад (8) болон төрийн бус (12) нийт 28 байгууллагын төлөөллийг багтаасан салбар дундын бодлого зохицуулалт



хариуцсан зөвлөх чиг үүрэг бүхий дэлхийн тэргүүн туршлагын жишээ юм.

Жендэрийн үндэсний хороо нь 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт 31 салбар хороо, төрийн захиргааны 14 төв байгууллага (яамд)-д салбар зөвлөлтэй, Хорооны Ажлын алба нь 14 ажилтантай, төрийн захиргааны төв байгууллагад 14, орон нутагт 31 жендэрийн мэргэжилтэнтэй ажиллаж байна. Мэргэжилтнүүд Жендэрийн салбар зөвлөл, хороодод нарийн бичгийн үүрэг гүйцэтгэж, жендэрийн асуудлыг үндсэн ажлын хамт хавсран гүйцэтгэж байна.

## ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО



### 3. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САНХҮҮЖИЛТ

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаас хойш 2011-2019 онуудад жендэрийн асуудлаар 12,469,841 ам.долларын хөрөнгө зарцуулсны 452,000 ам долларыг буюу 3.6 хувийг улсын төсвөөс, үлдсэн 96.4 хувийг Хөгжлийн албан ёсны туслалцаа (ХАЁТ)-ны хүрээний түншлэгчид олгожээ.



#### 2019-2020 оны санхүүжилтийн байдал (сая төг.)

	Улсын төсөвт (Ерөнхий сайдын багцад)	Орон нутгийн санхүүжилт	Олон улсын байгууллагын төслийн санхүүжилт
2019	706,8	766,1	232,2 (ЖҮХАА) 464 (Салбарын яамд)
2020	555,9	478,4	489.0 (ЖҮХАА)

## 4. ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах үүрэг бүхий байгууллагууд, түүний дотор ЖҮХ-ны Ажлын алба нь үйл ажиллагааныхаа хүрээнд дотоод, гадаадын төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо бүхий өргөн хүрээтэй түншлэлийг хөгжүүлэхээр чармайж байгаа бөгөөд ТХЗ-уудын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хөгжлийн үндсэн арга стратеги хэмээн үзэж бодлого, үйл ажиллагааныхаа чухал хэсэг болгодог НҮБ-ын тогтолцооны байгууллагууд, түүний дотор олон улсын санхүүгийн байгууллагууд, түүнчлэн Хөгжлийн албан ёсны туслалцааны хоёр талт бүх байгууллагатай хамтран ажиллаж байна.

- Гадаад хамтын ажиллагааны хүрээнд Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн агентлагууд, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк болон бусад хамтын ажиллагааны нийгэмлэг, төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. ЖҮХ-ны Ажлын албанаас санаачлан Гадаад харилцааны яамтай хамтран 2019 оны 4 дүгээр улирлаас эхлэн жендэрийн асуудлаар олон улсын хөгжлийн түншлэгчдийн уулзалтыг улирал тутамд зохион байгуулж байна. Тус уулзалт нь мэдээлэл болон санал солилцох замаар жендэрийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн уялдааг хангах, санхүүжилтийг оновчтой зарцуулах, жендэрийн талаар баримтлах төрийн бодлогын хэрэгжилтийг дэмжихэд хувь нэмэр оруулах юм.
- Жендэрийн үндэсний хорооны 2018 онд санаачлан зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн зорилт”, “Жендэр ба Хөгжил” олон улсын бага хурлаас уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн шинэ нөхцөл байдалд жендэрийн асуудлаарх олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн “Улаанбаатар тунхаглал”-ыг гаргав.
- Харамсалтай нь Засгийн газрын байгууллагууд, ТББ-уудын жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр гаргаж буй хүчин чармайлт, түүний дотор санхүүжилтийн талаар бүрэн дүүрэн мэдээлэл цуглуулж нэгтгэн харуулсан мэдээллийн тогтолцоо байхгүй нь тулгамдсан асуудал болж байна.

2016-2020 онуудад ЖҮХАА-аас олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран дараах томоохон төслүүдийг хэрэгжүүлээд байна. Үүнд:

- Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй “Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа” техникийн туслалцааны төсөл (санхүүжилт 700,000 ам. доллар);
- Швейцарын хөгжлийн агентлаг болон НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” техникийн туслалцааны төсөл (санхүүжилт 500,000 ам. доллар);
- Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй “Иргэний нийгмийн оролцоотойгоор жендэрийн тэгш байдлыг хангах нь” техникийн туслалцааны төсөл (санхүүжилт 500,000 ам. доллар).

- ЖҮХ-ны гишүүн ТББ-ууд, бусад хүний эрхийн болон хүний хөгжлийн чиглэлээр ажилладаг ТББ-уудтай дараах чиглэлээр тогтвортой хамтран ажиллаж байна. Үүнд:
  - Жендэрийн дүн шинжилгээ, түүний дотор төрийн албан дахь жендэрийн тэгш байдлын асуудлаар судалгаа үнэлгээ хийх;
  - Жендэрийн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
  - Жендэрийн тэгш байдлыг хангах эрхзүйн бодлогын орчныг сайжруулах, сургалтын тогтолцоог хөгжүүлэх;
  - Улс төр, нийгэм, соёлын хүрээнд, түүний дотор шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт нөлөөлөл хийх;
  - Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй, түүний дотор ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх;
  - Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал нэвтрүүлэх.
- Аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал нэвтрүүлэх, ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх болон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх талаар Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт үндэсний хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо болон холбогдох бусад төр, төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа эхлүүлээд байна.

## 5. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИК

Статистик үзүүлэлтүүд улсын дүн	Эмэгтэй	Эрэгтэй	Хугацаа
1. Монгол Улсын нийт хүн амын тоо	1 677 293	1 619 573	2019
2. Өрх толгойлсон хүн	69 787	17 775	2019
3. Төрөлтийн тоо	38 825	40 755	2019
4. Нас баралтын тоо	7 054	11 349	2019
5. Дундаж наслалт	75,96	66,38	2019
6. Нас баралтын зонхилох шалтгаан (зарим)			2019
Зүрх судасны тогтолцооны өвчин	2 251	3 280	
Хавдар	2 037	2 545	
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	5 57	2 270	
Амьсгалын тогтолцооны өвчин	519	654	
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	228	327	
7. 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо	555 320	633 120	2019 оны 4-р улирал
8. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	48,7%	60,8%	2019
9. Ажилгүйдлийн түвшин	7,3%	8,1%	2018
10. Аж ахуйн нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин	1 143,1 мян. төг.	1 371,6 мян. төг.	2020 оны 1-р улирал
11. Ажлын байр дахь хүнд болон хөнгөн осол гэмтлийн давтамжийн хувь			2016
Үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан амь нас хохирсон	1%	9.1%	
Үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан амь нас хохироогүй	36,6%	61,8%	
12. СӨБ-ийн хамран сургалтын цэвэр жин	81,5%		2019
13. ЕБС-т өдрөөр суралцагчид	319 900	320 500	2019
14. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид	15 547	22 259	2019
15. Их, дээд сургууль, коллежид суралцагчид	90 574	57 872	2019
16. Гэмт хэргийн улмаас хохирогчдын тоо (насанд хүрэгчид)	13 205	15 979	2019

17. УИХ-ын гишүүд	13	63	2020
18. Засгийн газрын гишүүд	3 (квот хангагдсан)	14	2020
19. Дэд сайд нар	2	12	2020
20. Яамдын Төрийн нарийн бичгийн дарга	1	12	2019
21. Засгийн газрын агентлагийн дарга	1	29	2019
22. Яамдын газар, хэлтэс, албадын дарга	66 (квот хангагдсан)	147	2019
23. ИТХ-ын дарга /аймаг, нийслэл/	0	22	2019
24. ИТХ-ын дарга /дүүрэг/	4 (квот хангагдсан)	5	2019
25. ИТХ-ын дарга /сум/	59	271	2019
26. Засаг дарга /аймаг, нийслэл/	0	22	2019
27. Засаг даргын орлогч /аймаг, нийслэл/	7 (квот хангагдсан)	32	2019
28. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга	4	18	2019
29. Засаг дарга /дүүрэг/	2 (квот хангагдсан)	7	2019
30. Засаг даргын орлогч /дүүрэг/	5 (квот хангагдсан)	15	2019
31. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга	1	8	2019
32. Засаг дарга/сум/	44	286	2019
33. Засаг даргын орлогч/сум/	61	269	2019
34. Сумын Засаг даргын Тамгын газрын дарга	189	141	2019
35. Жендэрийн хөгжлийн индекс	0,750	0,720	2019
36. Жендэрийн тэгш бус байдлын индекс	0,274		2019

Эх сурвалж: Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, ҮСХ-ны 1212.мн, ЖҮХ АА, НҮБХХ-ийн 2019 оны Хүний Хөгжлийн илтгэл